



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Нийслэлийн хэмжээнд эх барих,
эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ
үзүүлэх хүрээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор нийслэлийн хэмжээнд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хуваарийг шинэчилж, хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хуваарийн дагуу тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Ж.Нарангэрэл), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Алтантуяа), Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II (А.Эрдэнэтуяа), Өргөө амаржих газар (Ж.Энхцэцэг), Хүрээ амаржих газар (А.Жаргал), Амгалан амаржих газар (Ц.Батболд), Нийслэлийн эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж)-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/130 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141220168

Эрүүл мэндийн сайдын
2022 оны ... сарын ... ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт



ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	Эх барихын тусламжийн үйлчлэх хүрээ	Эмэгтэйчүүдийн тусламжийн үйлчлэх хүрээ
1.	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг	- Хөдөө орон нутгийн жирэмслэлт, төрөлттэй холбоотой тусламж - Сонгинохайрхан дүүргийн 5-11, 24, 25, 28 дугаар хороо	- Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ - Баянгол дүүргийн бүх хороо - Сонгинохайрхан дүүргийн 5-21, 23-36, 38, 39, 43 дугаар хороо
2.	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II	- Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9,10,12,13,14,16, 21-р хороо - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 37, 40, 41, 42 дугаар хороо	- Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 21-р хороо - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 37, 40, 41, 42 дугаар хороо
3.	Өргөө амаржих газар	- Баянгол дүүргийн бүх хороо - Чингэлтэй дүүргийн бүх хороо - Багахангай дүүргийн бүх хороо - Хан-Уул дүүргийн 1, 2, 3, 11, 15, 17, 18, 19, 20-р хороо - Сүхбаатар дүүргийн 1-11 дүгээр хороо	- Чингэлтэй дүүргийн бүх хороо - Багахангай дүүргийн бүх хороо - Хан-Уул дүүргийн 1, 2, 3, 11, 15,17,18,19, 20-р хороо - Сүхбаатар дүүргийн 1-11 дүгээр хороо
4.	Хүрээ амаржих газар	- Сонгинохайрхан дүүргийн 1-4, 12-23, 26, 27, 29-36, 38, 39, 43 дугаар хороо	- Сонгинохайрхан дүүргийн 1-4, 22 дугаар хороо
5.	Амгалан амаржих газар	- Баянзүрх - Сүхбаатар дүүргийн 12-20 дугаар хороо	- Баянзүрх - Сүхбаатар дүүргийн 12-20 дугаар хороо
6.	Багануур Эрүүл мэндийн төв	Багануур дүүргийн бүх хороо	Багануур дүүргийн бүх хороо
7.	Налайх эрүүл мэндийн төв	Налайх дүүргийн бүх хороо	Налайх дүүргийн бүх хороо